



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар сарын 22

Дугаар 03/06

Жаргалант сум

「 Сумын Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, шаардлагатай үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий сумын Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцэст иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар 09-ний өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Ш БИЛГҮҮНБААТАР

6125010007

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
04 дүгээр сарын 22 ны өдрийн ээлжит бус
II хуралдааны 03/06 дугаар тогтоолын хавсралт

ЖАРГАЛАНТ СУМЫН ХАМТАРСАН БАГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

- Багийн ахлагч: Сумын Засаг дарга
- Нарийн бичгийн дарга: Жаргалант сумын Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан
- Гишүүд: Сумын хэсгийн төлөөлөгч
ЗДТГ-ын хууль, эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн
Дулаан-Уул багийн Засаг дарга
Жаргалант сумын Засаг дарга
Улаантолгой багийн Засаг дарга
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн
Сумын нийгмийн ажилтан
Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн
ажилтан
3-р цэцэрлэгийн арга зүйч
Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан